



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 32-27-77, Факс: 32-70-16

E-mail: lundeejantsan@parliament.mn

<http://www.parliament.mn>

2018.04.18 № 4200

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, төсөл, төслийн үр нөлөөг үнэлсэн тайланг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 32-27-77, Факс: 32-70-16
E-mail: lundeejantsan@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018. 04. 10 № *3805*

танай _____-ны № _____-т


Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулсан тул төсөл, холбогдох баримт бичгийг хянан үзэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, төсөл, төслийн үр нөлөөг үнэлсэн тайланг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 18 он 04 дугаар
сарын 18 ны өдөр

Дугаар ХЭГ/
776

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ЛҮНДЭЭЖАНЦАН ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Р.ЗАНДАНШАТАР

003052

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэлд:

"III.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцангийн санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцангийн санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

"Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ...эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ..." гэсэнд нийцүүлэх үүднээс "Улсын Их Хурлын гишүүнийг гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан" гэснийг өргөжүүлэн "Улсын Их Хурлын гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан" бол Улсын Их Хуралд оруулан хэлэлцүүлэхээр тусгасан хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “судалж” гэсний дараа “санал, дүгнэлт гарган” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.9. Доор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ:

6.9.1. гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;

6.9.2. гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан.”

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11, 6.12, 6.15 дахь хэсгийн “6.9.1-д” гэснийг “6.9.1, 6.9.2-т” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2018 оны ... дүгээр сарын ... -ны өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

БАТЛАВ:
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж, 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын эрх зүйн үндсийг заасан.

Улсын Их Хурлаас 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ыг баталсан бөгөөд уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийн 6.9.1-д “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан”, 6.9.2-т “гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан” гэсэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх 2 үндэслэлийг заасан байсан.

2010 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан гэсэн 6.9.2 дахь заалтыг хүчингүй болгосон. Ингэснээр зөвхөн гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилсан тохиолдолд бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг хэлэлцэх зохицуулалттай болсон.

Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1-д “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон.

Улмаар Улсын Их Хурлаас 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 6.9 дэх хэсгийг “6.9.Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулах бөгөөд Улсын Их Хурал гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ: 6.9.1.гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн

газарт нотлох баримттайгаар баривчилсан” гэж өөрчлөн найруулсан боловч Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 02 дугаар тогтоолоор уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1-д “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг тус тус зөрчсөн гэж үзсэн. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцээс өмнө нь хүчингүй болгосон заалтыг агуулгаар нь дахин сэргээж баталсан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасныг зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.” гэж заасан бөгөөд дээрх 6.9.1 дэх заалтыг хүчингүй болгосноор Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасан зохицуулалт хэрэгжих боломжгүй байдал үүсэж, ямар ч тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийх, гишүүний халдашгүй байдлыг хязгаарлах боломжгүй болсон.

Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 03 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэрбээр Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна” гэж заасны “...санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, ..., хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”; мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”; мөн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. ...”; Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзэж “...санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэснийг хүчингүй болгосон.

Ийнхүү хүчингүй болгосноор Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар судлах боловч эрх зүйн ямар үр дагавар бүхий шийдвэр гаргаж зохих Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд оруулах нь

тодорхойгүй болсон.

Иймд Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон асуудлыг хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол гишүүнээс нь эгүүлэн татах талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос гарах шийдвэрийг тодорхой болгох үндэслэл, шаардлагад үндэслэн энэхүү хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг үндэслэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Энэхүү хуулийн төсөл нь 4 зүйлтэй байх бөгөөд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар судалж санал, дүгнэлт гаргах зохицуулалт нэмж, гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт эд мөрийн баримттайгаар баривчилсан болон гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэлээр гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулах харилцааг зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон асуудлыг хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол гишүүнээс нь эгүүлэн татах зохицуулалт хэрэгжих нөхцөл бүрдэж, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын хязгаарлалт бий болно.

Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт эд мөрийн баримттайгаар баривчилсан, эсхүл гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулах бөгөөд Улсын Их Хурал гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаар

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж, 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын эрх зүйн үндсийг заасан.

Үүний дагуу Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг тогтоож, гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд гишүүний бүрэн эрхийн асуудлыг хэрхэн авч шийдвэрлэх талаарх зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт заасан.

Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 02 дугаар тогтоолоор дээрх хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1-д “гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон.

Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж заасан зохицуулалт хэрэгжих боломжгүй байдал үүссэн.

Иймд гишүүний халдашгүй байдлын зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн, Үндсэн хуулийн цэцийн 2 удаагийн тогтоолд үндэслэн Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт эд мөрийн баримттайгаар баривчилсан болон гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэлээр гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулахаар, уг асуудлаар Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос санал, дүгнэлт гаргахаар хуулийн төслийг боловсруулсан.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

Энэхүү үнэлгээг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн төрлөөр боловсруулагдсан хувилбар бөгөөд үр нөлөөний үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-д заасан үе шатны дагуу хийлээ.

Нэг.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу “Зорилгод хүрэх байдал”, “Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг сонголоо.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцсэн эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг Улсын Их Хурал, сонгогчид болон Үндсэн хуулийн цэц хүлээн зөвшөөрөх эсэх үр нөлөөг үнэлнэ.

Хуулийн төсөл нь Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалтай холбоотой асуудлыг тусгасан, шинээр зардал нэмэгдэх зохицуулалт байхгүй тул “практикт хэрэгжих боломж”, “ойлгомжтой байдал”, “зардал”, “харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзэв.

Хоёр.Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийв.

Хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн бүтэц, агуулгаас үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн

татна.” гэж заасан зохицуулалт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын хязгаарлалтыг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулахаар заасан байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд заасан Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх 2 үндэслэл хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд дүн шинжилгээ хийв.

Гурав.Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн үзэл баримтлалт заасан зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 6.9.1, 6.9.2	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн заалтууд, хуулийн хувийн хэргүүд, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцахад Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон асуудлыг хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол гишүүнээс нь эгүүлэн татах талаархи Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын хязгаарлалтыг тодорхой болгоно гэж хуулийн төслийн зорилгыг заажээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт хуулийн төсөлд туссан гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан болон гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан үндэслэлийг нэмснээр Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын хязгаарлалт тодорхой болохоор байгаа тул уг хуулийн төслийн үзэл баримтлал дахь зорилгод хүрэх боломжтой байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд заасан Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх 2 үндэслэлийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг авч үзэхээр сонгосон.

Хуулийн төсөлд заасан 2 үндэслэл нь Улсын Их Хурлын гишүүний халдашгүй

байдалтай холбоотой, Улсын Их Хурлын гишүүдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөж байгаа тул Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх, уг заалтыг Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгосон тул хуулийн төслийг Үндсэн хуулийн цэц хүлээн зөвшөөрөх эсэх, Улсын Их Хурлын гишүүдийг нийт ард түмнээс сонгодгоос гадна энэхүү заалтыг иргэдийн мэдээллээр маргаан үүсгэж хянан шийдвэрлэсэн тул иргэд хүлээн зөвшөөрөх эсэхэд үнэлгээ хийхийн тулд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын хязгаарлалтыг хууль тогтоомжид хэрхэн тусгаж байсан, энэ талаар иргэд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаж байсан байдал, мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэцээс гарсан шийдвэрүүдийн талаар судлан үзье.

Д/Д	ОГНОО	ГАРСАН ШИЙДВЭРҮҮД	ХУУЛИЙН ЗААЛТ
1.	2006.01.26	Улсын Их Хурлаас Монгол Улсын Их Хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан. Хуулийн 6.9-д гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх 2 үндэслэл заасан.	6.9.Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ: 6.9.1.гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан; 6.9.2.гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан.
2.	2010.12.30	Улсын Их Хурлаас Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 6.9.2-т заасан УИХ-ын гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэлээр бүрэн эрхийг түдгэлзүүлэх заалтыг хүчингүй болгосон. Ингэснээр зөвхөн гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилсан тохиолдолд бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг хэлэлцэхээр болсон.	6.9.Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ: 6.9.1.гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан; 6.9.2.гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан.
3.	2011.10.21	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар 03 дугаар дүгнэлт гаргаж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6.9.1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14.1, 14.2, 29.3-т заасныг зөрчсөн гэж үзсэн.	өрүүлсэн.
4.	2012.01.12	Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тухай 05 дугаар тогтоол баталсан.	
5.	2012.02.15	Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар 02 дугаар тогтоол гаргаж, Монгол Улсын Их	6.9.Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ:

		Хурлын тухай хуулийн 6.9.1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14.1, 14.2, 29.3-т заасныг зөрчсөн гэж үзэж, хүчингүй болгосон.	6.9.1.гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;
6.	2013.01.17	Ерөнхийлөгчөөс УИХ-ын гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх 2 үндэслэлийг заасан хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн хэлэлцүүлгийн шатанд төслийн 6.9.2-ыг хасаж, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. /Өргөн мэдүүлсэн төсөл: 6.9.1.гэмт хэрэг үйлдэж байхад нь хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан; 6.9.2.гэмт хэрэгт холбогдуулан яллагдагчаар татах зайлшгүй шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаагчийн саналыг үндэслэн/	6.9.Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулах бөгөөд Улсын Их Хурал гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ: 6.9.1.гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан.
7.	2017.12.20	Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар гарсан 02 дугаар тогтоолоор 6.9.1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14.1, 14.2, 29.3-т заасныг зөрчсөн гэж үзэж, хүчингүй болгосон.	6.9.Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулах бөгөөд Улсын Их Хурал гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ: 6.9.1.гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан.

Дээрх лавлагаанаас үзэхэд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хязгаарлах үндэслэлийг хуульд тусгахдаа гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилсан болон гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулсан гэсэн 2 үндэслэлийг заасан тохиолдолд энэ талаар аливаа маргаан үүсгэж байгаагүй байна.

Харин зөвхөн гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилсан үндэслэлийг заасан тохиолдолд энэ талаар иргэд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаж, Үндсэн хуулийн цэцээс Улсын Их Хурал гишүүний халдашгүй байдлын хязгаарлалтыг заахдаа Үндсэн хуулийн заалтын агуулгыг хэт явцууруулан, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нийтлэг зарчимд харшилсан шинжийг агуулсан, мөн гэмт хэрэгт холбогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх, улмаар Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоох боломжийг хязгаарлаж байгаа нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх эрүүгийн эрх зүйн суурь зарчим зөрчигдөхөд хүргэсэн гэж үзэж, 2012 оны 02

дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтыг хүчингүй болгосон байна.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, 6.9 дэх хэсгийг өөрчлөн найруулсныг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж гаргасан иргэдийн мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж, өмнө нь Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгосон заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн гэж үзэж хүчингүй болгосон байна.

Иймд гишүүний халдашгүй байдлыг хязгаарлах үндэслэлд гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан болон гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулсан гэсэн 2 үндэслэлийг хамтад нь заасан тохиолдолд Үндсэн хуулийн цэц болон иргэд хүлээн зөвшөөрнө гэж үзэх үндэслэлтэй байна. Улсын Их Хурлын хувьд Үндсэн хуулийн цэцээс удаа дараа хүчингүй болгосон байдлыг харгалзан үзэж, хууль батлах онцгой бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх боломжтой юм. Иймд хуулийн төслийн заалт хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангаж байна.

Дөрөв.Дүгнэлт

Хуулийн төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалт нь Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон асуудлыг хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол гишүүнээс нь эгүүлэн татах талаархи Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын хязгаарлалтыг тодорхой болгохоор тусгасан байх тул төслийг уг хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан гэж дүгнэсэн.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төсөлд заасан Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх 2 үндэслэлийг Үндсэн хуулийн цэц, Улсын Их Хурал, иргэд хүлээн зөвшөөрөх эсэхэд үнэлгээ хийхэд Үндсэн хуулийн цэц болон иргэд, сонгогчдын хувьд хуулийн заалтыг хүлээн зөвшөөрөх боломжтой байна.

Улсын Их Хурлын хувьд Үндсэн хуулийн цэцээс удаа дараа хүчингүй болгосон байдлыг харгалзан үзэж, хууль батлах онцгой бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх боломжтой юм.